



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2013 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 140


Улаанбаатар
хот

Шуудангийн маркийн сэдвийн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Шуудангийн тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2014-2015 онд хэвлэгдэх шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Ерөнхий сайдын 2013 оны 140 дүгээр
захирамж хавсралт

2014-2015 ОНД ХЭВЛЭГДЭХ ШУУДАНГИЙН
МАРКИЙН СЭДВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Маркийн сэдэв	Маркийн нэр төрөл	Тайлбар
2014 онд хэвлэгдэх шуудангийн маркийн сэдэв			
1	Морь жил	2 нэрийн	Уламжлалт аргаар хийнэ
2	Монгол маркийн 90 жил	1 блок	Монгол маркийн 90, Монгол Улсад шуудан өртөө байгуулагдсаны 778 жилийн ойг тохиолдуулан 50 центийн очиртой марк, гэрэгэ бүхий морьтой улаач зэргийг дүрслэнэ
3	Дэлхийн нэрт эрдэмтэд	6 нэрийн	Чарльз Дарвин, Альберт Эйнштейн, Леонардо Да Винчи, Исаак Ньютон, Нилс Бор зэрэг эрдэмтдийн хөрөг байдлаар хийнэ
4	Монгол орны улаан номд шинээр орсон ан амьтад	1-4 нэрийн	Эрээн хүрэн, хандгай, халбаган хошуут, тэмээн сүүлт могой, цоохондой, ойн цаа буга зэрэг амьтадаас сонголт хийнэ
5	Монгол уран зураг	7 нэрийн	Ц.Даваахүү, Г.Соосой, А.Сэнгэцохио, Б.Аварзэд, Ц.Жамсран зэрэг зураачдын алдартай зургуудаар марк хийнэ
6	Хөл бөмбөгийн ДАШТ	2 нэрийн	Дэлхийн хөлбөмбөгийн холбооноос тавьдаг шаардлагын дагуу хийнэ
7	Ирвэс	1-4 нэрийн	Ирвэсийг дүрсэлж хийнэ
8	Монголбанкны 90 жил	1 блок	Монголын мөнгөн дэвсгэртийн түүхийг харуулан хийнэ
9	Монгол цэргийн хувцасны түүх	6 нэрийн	Монгол цэргийн хувцасны түүхийг Хүннү гүрэн, XIII зуун, XVI зуун, Богд хаант улс, 1939-1945 он, орчин үеийн байдлаар дүрслэн хийнэ
10	Тэмдэглэлт ой	1 багц	Анхдугаар үндсэн хуулийн 90 жил, Дэлхийн шуудан холбооны 140 жил, ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоосны 40 жил, Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 280 жилийн ойд зориулан хийнэ
11	Тарифын марк	4 нэрийн	Чингис хааныг дүрсэлж тарифын марк хийнэ
12	Байгаль хамгаалал	1 нэрийн	Усаа хайрлан хамгаалах сэдвийн дор хийнэ
13	Нөөц сэдэв 4		
14	Тусгай сэдэв 2		

2015 онд хэвлэгдэх шуудангийн маркийн сэдэв			
1	Хонь жил	2 нэрийн	Уламжлалт аргаар хийнэ
2	Их Монгол Улс байгуулагдсаны 810 жил	1 блок	Чингис хааны зураг бүхий марк гаргана
3	Тэмдэглэлт ой	1 багц	Эх орны дайны ялалтын 70 жил, Агаарын тээврийн 90 жил, НҮБ-ын 70 жилийн ойд зориулан хийнэ
4	Торгоны зам	1-2 нэрийн	Торгоны замыг харуулсан газрын зураг, тэмээн жингийн цуваа зэргийг дүрслэнэ
5	Монгол гэр, үндэсний хувцас	5 нэрийн	Монгол гэр болон үндэсний хувцсыг хээ угалзан чимэглэл бүхий зургаар илэрхийлж хийнэ
6	Ардын гар урлал	1-4 нэрийн	Алдартай уран дархчуудын төрөл бүрийн материалаар хийсэн бүтээлүүдээс сонгож хийнэ
7	Шинэ жилийн марк	1 нэрийн	
8	Зодоонч ноход	5 нэрийн	Зодоонч ноход болон монгол, түвд банхарыг дүрсэлж хийнэ
9	Сүм хийдүүд	1 блок	Амарбаясгалант хийдийн гоёмсог барилга, ур хийц, гоёл чимэглэлийг дүрсэлж хийнэ
10	Эвтэй 4, Цэрэндүг, Дугар зайсан, Эрдэнийн заан	4 мини блок	Эдгээр 4 зүйлийн билэгдлийг тус тусад нь блок болгон гаргана
11	Хурдан морь	1 блок, 4 нэрийн	Монгол морины тухай гоёмсог марк хийнэ
12	Монголын сансрын холбооны хиймэл дагуул	1 блок	
13	Нөөц сэдэв 4		
14	Тусгай сэдэв 2		